



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 01119

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 67 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн Өмчийг хувьчлах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв”, “Багахангай Мах боловсруулах үйлдвэр” ОНӨААТҮГ-ын хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог хавсралт ёсоор баталсугай.

2. Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо /Д.Рэнцэнбямба/-д үүрэг болгосугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийн архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга Б.Мөнгөнхүүд үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны .04 дүгээр сарын 06 өдрийн 0/118 тоот тушаалын хавсралт



ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДХҮҮН

Дарга:	Д.Рэнцэнбямба	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч дарга
Гишүүд:	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга
	А.Мөнгөн	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
	Д.Содномдорж	Баянгол дүүргийн 7 дугаар хороо, 3 дугаар хороололын 69-37 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнгөнхүү	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн